



**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ,
ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА
ЭРХЛЭГЧДИЙН 2025 ОНЫ I
УЛИРЛЫН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газар

Улаанбаатар хот
2025 он



АГУУЛГА

1

САЛБАРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2

АРИЛЖААНЫ МЭДЭЭ

3

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
ҮЗҮҮЛЭЛТ**

4

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

5

ДУГНЭЛТ



Товчилсон үгийн тайлал

1. Хороо-Санхүүгийн зохицуулах хороо
2. ҮМҮЧЭТХЭАЭ-Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч
3. АНУ - Америкийн Нэгдсэн Улс
4. ХБНГУ - Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
5. ХЭ - Хувьцаа эзэмшигч
6. ХНХ - Хувь нийлүүлсэн хөрөнгө
7. ГХО - Гадаадын хөрөнгө оруулалт
8. ЭБАТ– Эрх бүхий албан тушаалтны шийдвэрлэлт

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн байршил

Хүснэгт 2. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Хүснэгт 3. Орлогын тайлангийн үзүүлэлт

Дүрслэл 1. Тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо

Дүрслэл 2. Салбар нээх хүсэлт болон эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийн шийдвэрлэлт

Дүрслэл 3. Арилжаа эрхлэгчид байршлаар

Дүрслэл 4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (мянган төгрөгөөр)

Дүрслэл 5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц

Дүрслэл 6. ГХО-ын дэлгэрэнгүй

Дүрслэл 7. Хувьцаа эзэмшигчид

Дүрслэл 8. Үнэт металлын борлуулалтын хэмжээ

Дүрслэл 9. Алтны борлуулалтын хэмжээ

Дүрслэл 10. Мөнгөний борлуулалтын хэмжээ

Дүрслэл 11. Үнэт эдлэлийн борлуулалтын мэдээ

Дүрслэл 12. Монголбанкны худалдан авсан үнэт металлын мэдээ

Дүрслэл 13. Монгол Улсын худалдан авахаар төлөвлөсөн алт болон Монголбанкны худалдан авсан алт (2020-2023 он)



Хураангуй

Тусгай зөвшөөрөл эзэмшигчид:

Хорооноос 2025 оны I улиралд 14 иргэнд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосноор нийт 55 хуулийн этгээд, 485 иргэн энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэхээр тус Хороонд бүртгэгдсэн байна.

Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдүүдээс хаяг, байршлын өөрчлөлт бүртгүүлэх тухай 2 хүсэлт ирүүлснийг хянаж, шийдвэрлэлээ.

Арилжааны мэдээ, санхүүгийн үзүүлэлт:

Тайлант улиралд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 55 хуулийн этгээд нь 85 хувьцаа эзэмшигчийн 10,164,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн 55.2 хувийг дотоодын хөрөнгө оруулалт, 44.8 хувийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна.

Нэр бүхий 55 хуулийн этгээд нь тайлант хугацаанд 27,993,589.2 мянган төгрөгийн нийт орлоготой, 23,654,237.8 мянган төгрөгийн нийт зардалтайгаар үйл ажиллагаа эрхэлснээр 4,339,351.4 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь 2024 оны I улиралтай харьцуулахад цэвэр ашиг нь 8.0 хувиар буурсан байна.

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 282.1 кг үнэт металлыг 35,639,077.2 мянган төгрөгөөр худалдан авч, 193.1 кг үнэт металлыг 34,782,370.8 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан үнэт металлын хэмжээ 17.1 хувиар, худалдсан үнэт металлын хэмжээ 15.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.


ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 2025 оны I улирлын байдлаар 119.1 кг алтыг 34,700,228.4 мянган төгрөгөөр худалдан авч, 114.8 кг алтыг 33,691,491.4 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь өмнөх оны мөн үеэс худалдан авсан алтны хэмжээ 52.8 хувиар, худалдсан алтны хэмжээ 44.0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид нь нийт 163.0 кг мөнгийг 938,848.8 мянган төгрөгөөр худалдан авч, 78.3 кг мөнгийг 1,090,879.4 мянган төгрөгөөр худалдан борлуулсан бөгөөд 2024 оны I улиралтай харьцуулахад худалдан авсан мөнгөний хэмжээ 1.9 дахин, худалдан борлуулсан мөнгөний хэмжээ 3.3 дахин өссөн үзүүлэлт юм.

Хурал уулзалт:

- “Тайлагнал болон МУТС-тэй тэмцэх чиглэл” сэдэвт мэдлэг олгох сургалтад ҮМҮЧЭТХЭА-ийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдүүдийн эрх бүхий албан тушаалтнуудад 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан.
- ОХУ-ын Санкт Петербург хотод зохион байгуулсан олон улсын эрдэнийн чулуу, үнэт эдлэлийн “JUNWEX SAINT PETERBURG 2025” үзэсгэлэнд Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл 2025 оны 02 дугаар сарын 05-09-ний өдрүүдэд оролцож, туршлага солилцсон.

Тайлант улиралд буюу 2025 оны I улирлын байдлаар нэр бүхий 55 хуулийн этгээд, 485 иргэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхэлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо 5.8 хувиар, иргэдийн тоо 11.8 хувиар тус тус өссөн үзүүлэлт байна.



Дүрслэл 1. Тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо

Тайлант улиралд нэр бүхий 14 иргэнд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бөгөөл нэр бүхий 2 хуулийн этгээдийн хаяг байршлын өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлтийг шийдвэрлэж Дүрслэл 2, 3-т үзүүлэв.



Дүрслэл 2. ТЗ-ийн хүсэлт



Дүрслэл 3. Хаягийн өөрчлөлт хийлгэх тухай хүсэлт

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй иргэдийн 73.2 хувь буюу 355 нь Улаанбаатар хотод, 26.8 хувь буюу 130 иргэн орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэн, хуулийн этгээдүүдийг байршлаар ангилбал:

Дүүрэг	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд	Үнэт металл, үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд	Үнэт металл, үнэт чулууны, арилжаа эрхлэгч иргэд	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээд
Сүхбаатар	4	7	4	14
Хан-Уул	3	8	1	13
Баянзүрх	5	7	8	3
Чингэлтэй	67	164	29	17
Баянгол	13	17	2	5
Сонгинохайрхан	5	9	1	2
Орон нутаг	52	7	72	1

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн байршил


Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 130 иргэдийн 72.3 хувь буюу 94 нь Баянхонгор, Өмнөговь, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол 27.7 хувь буюу 36 нь Увс, Баян-Өлгий, Ховд, Өвөрхангай, Дорноговь, Дорнод, Хэнтий, Говьсүмбэр, Говь-Алтай, Орхон, Архангай аймгуудад үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн тусгай зөвшөөрөлтэй 55 хуулийн этгээдийн 1 нь орон нутагт буюу Баянхонгор аймагт үйл ажиллагаа эрхэлж байна. Арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхэлж буй байршлын дэлгэрэнгүйг дүрслэл 3-т үзүүлэв.



Дүрслэл 3. Арилжаа эрхлэгчид байршлаар

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгө ↑ 1.5%


Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 55 хуулийн этгээд нь 85 хувьцаа эзэмшигчийн 10,164,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувьцаа эзэмшигчдийн тоо 1.2 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.




Дүрслэл 4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ

Дээрх 55 хуулийн этгээдийн 10,164,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 55.2 хувийг дотоодын хөрөнгө оруулалт, 44.8 хувийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтцийг дүрслэл 5-д үзүүлэв.


Нийт гадаадын хөрөнгө оруулалтын 82.1 хувь буюу 3,739,923.0 мянган төгрөгийг БНСУ, 17.9 буюу 816,000.0 мянган төгрөгийг АНУ, Япон, ХБНГУ-ын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна. Гадаадын хөрөнгө оруулалтын дэлгэрэнгүйг дүрслэл 6-д үзүүлэв.



Дүрслэл 5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц



Дүрслэл 6. ГХО-ын дэлгэрэнгүй



Дүрслэл 7. Хувьцаа эзэмшигчид

Тусгай зөвшөөрөлтэй 55 хуулийн этгээдийн 35 нь 1 хувьцаа эзэмшигчтэй, 14 нь 2 хувьцаа эзэмшигчтэй, 6 нь 3 буюу түүнээс дээш хувьцаа эзэмшигчтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байна. Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдүүдийг хувьцаа эзэмшигчдийн тоогоор нь ангилан дүрслэл 7-д үзүүлэв.

Үнэт металлын борлуулалтын тойм

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 282.1 кг үнэт металлыг 35,639,077.2 мянган төгрөгөөр худалдан авч, 193.1 кг үнэт металлыг 34,782,370.8 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь 2024 оны I улиралтай харьцуулахад худалдан авсан үнэт металлын хэмжээ 17.1 хувиар, худалдсан үнэт металлын хэмжээ 15.7 хувиар тус тус буурсан үзүүлэлтэй байна. Үнэт металлын борлуулалтыг дүрслэл 8-д үзүүлэв.



Дүрслэл 8. Үнэт металлын борлуулалтын хэмжээ

ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 2025 оны I улирлын байдлаар 119.1 кг алтыг 34,700,228.4 мянган төгрөгөөр худалдан авч, 114.8 кг алтыг 33,691,491.4 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь 2024 оны I улиралтай харьцуулахад худалдан авсан алтны хэмжээ 52.8 хувиар, худалдсан алтны хэмжээ 44.0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Алтны борлуулалтын хэмжээг дүрслэл 9-д үзүүлэв.



Дүрслэл 9. Алтны борлуулалтын хэмжээ

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид нь нийт 163.0 кг мөнгийг 938,848.8 мянган төгрөгөөр худалдан авч, 78.3 кг мөнгийг 1,090,879.4 мянган төгрөгөөр худалдан борлуулсан бөгөөд 2024 оны I улиралтай харьцуулахад худалдан авсан мөнгөний хэмжээ 1.9 дахин, худалдан борлуулсан мөнгөний хэмжээ 3.3 дахин өссөн үзүүлэлт юм.



Дүрслэл 10. Мөнгөний борлуулалтын хэмжээ

Үнэт эдлэлийн борлуулалтын тойм



Дүрслэл 11. Үнэт эдлэлийн борлуулалтын дүн (мянган төгрөг)

Тайлант хугацаанд ҮМҮЧЭТХЭАЭ иргэн, хуулийн этгээдүүд 5,759,920.6 мянган төгрөгийн үнэт эдлэл худалдан авсан бөгөөд 12,592,124.6 мянган төгрөгийн үнэт эдлэлийг худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс худалдан авсан үнэт эдлэлийн дүн 1.1 хувиар буурсан бол худалдан борлуулсан үнэт эдлэл дүн 30.3 хувиар өссөн үзүүлэлт байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2024.1	Нийт хөрөнгөд ЭЗЛЭХ ХУВЬ	2025.1	Нийт хөрөнгөд ЭЗЛЭХ ХУВЬ
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	16,215,675.0	23.0%	11,566,297.4	13.5%
Дансны авлага	3,131,936.5	4.4%	6,228,332.3	7.3%
Татвар, НДШ – ийн авлага	413,620.2	0.6%	583,472.6	0.7%
Бусад авлага	1,349,074.5	2.0%	2,415,697.6	2.8%
Бусад санхүүгийн хөрөнгө	22,408.0	0.0%	5,100.0	0.0%
Бараа материал	29,790,611.2	42.2%	36,083,058.4	42.0%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5,387,730.8	7.6%	15,214,327.2	17.7
Бусад эргэлтийн хөрөнгө	451,245.6	0.6%	41,142.1	0.0%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	1,756,445.3	2.5%	1,550.0	0.0%
Эргэлтийн хөрөнгийн дүн	58,518,747.0	82.9%	72,138,977.8	84.0%
Үндсэн хөрөнгө	11,090,336.0	15.7%	12,299,723.1	31.5%
Биет бус хөрөнгө	525,166.5	0.7%	1,000,465.3	1.2%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	407,374.1	0.6%	408,604.1	0.5%
Хойшлогдсон татварын хөрөнгө	34,450.1	0.1%	29,015.8	0.0%
Бусад хөрөнгө			7,386.0	0.0%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	12,057,326.7	17.1%	13,745,194.3	16.0%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	70,576,073.6	100%	85,884,172.0	100.0%
Дансны өглөг	18,993,033.6	26.9%	17,742,667.7	20.7%
Цалин, татвар, НДШ-ийн өглөг	1,951,281.80	3.0%	3,166,085.9	3.7%
Банкны богино хугацаат зээл	1,450,171.7	2.1%	3,432,246.2	4.0%
Хүүний өглөг	784,411.2	1.1%	1,028,764.4	1.2%
Ногдол ашгийн өглөг	202,500.0	0.3%		
Урьдчилж орсон орлого	1,848,527.1	2.6%	7,018,021.6	8.2%
Нөөц /өр төлбөр/	16,869.7	0.0%	15,654.1	0.0%
Бусад богино хугацаат өр төлбөр	6,674,963.9	9.5%	6,584,636.2	7.7%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	31,921,759.0	45.9%	38,988,076.1	45.4
Урт хугацаат өр төлбөр			-	0.0%
Урт хугацаат зээл	7,131,759.0	10.8%	10,653,620.4	12.4%
Хойшлогдсон татварын өр	5,050.0	0.0	10,097.2	0.0%
Бусад урт хугацаат өр төлбөр	0.0	-	214,174.3	0.2%
Урт хугацаат өр төлбөрийн дүн	7,136,809.1	10.1%	10,877,891.9	12.7
Өр төлбөрийн нийт дүн	39,058,568.1	55.3%	49,865,968.0	58.1
Өмч	10,013,429.1	14.2%	10,164,429.1	11.8%
- хувийн	10,013,429.1	14.2%	10,164,429.1	
Халаасны хувьцаа			-168,000.0	-0.2%
Нэмж төлөгдсөн капитал	2,278,232.1	3.2%	2,278,232.1	2.7%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	288,263.9	0.4%	873,381.7	1.0%
Эздийн өмчийн бусад хэсэг	1,096,032.1	1.6%	1,423,009.6	1.7%
Хуримтлагдсан ашиг	17,841,548.5	25.3%	21,447,151.6	25.0%
Эздийн өмчийн дүн	31,517,505.5	44.7%	36,018,204.0	41.9
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	70,576,073.6	100%	85,884,172.0	100.00%

2024.I

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын 2024 оны I улирлын тайлангийн нэгтгэлд 52 хуулийн этгээд хамрагдсан бөгөөд 84 хувьцаа эзэмшигчдийн 10,013,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 70,576,073.6 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.

Эргэлтийн
хөрөнгө

82.9%

Эргэлтийн
бус хөрөнгө

17.1%

Эздийн өмч

44.7%

Өр төлбөрийн
хэмжээ

55.34%

2025.I

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын 2025 оны I улирлын тайлангийн нэгтгэлд 55 хуулийн этгээд хамрагдсан бөгөөд 85 хувьцаа эзэмшигчдийн 10,164,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 85,884,172.0 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.

Эргэлтийн
хөрөнгө

84.0%

Эргэлтийн
бус хөрөнгө

16.0%

Эздийн өмч

41.9%

Өр төлбөрийн
хэмжээ

58.1%

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1.5 хувиар, хуримтлагдсан ашгийн хэмжээ 20.2 хувиар, нийт хөрөнгийн хэмжээ 21.7 хувиар тус тус өссөн байна.

Хувь нийлүүлсэн
хөрөнгийн хэмжээ



Хуримтлагдсан
ашгийн хэмжээ



Нийт хөрөнгийн
дүн





Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

2024.I

2025.I

Нийт орлого
25,918,798.0 мянган төгрөг

Борлуулалтын орлого
25,655,869.9 мянган төгрөг

Нийт зардал
21,203,546.5 мянган төгрөг

Цэвэр ашиг 4,715,251.4 мянган төгрөг

Нийт орлого
27,993,589.2 мянган төгрөг

Борлуулалтын орлого
27,716,089.5 мянган төгрөг

Нийт зардал
23,654,237.8 мянган төгрөг

Цэвэр ашиг 4,339,351.4 мянган төгрөг

- ◆ Тайлант хугацаанд нэр бүхий 55 хуулийн этгээд нь 27,993,589.2 мянган төгрөгийн нийт орлоготой, 23,654,237.8 мянган төгрөгийн нийт зардалтайгаар үйл ажиллагаа эрхэлсэн байна.
- ◆ Мөн ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүд нь 4,339,351.4 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс цэвэр ашгийн хэмжээ 375,900.0 мянган төгрөгөөр буюу 8.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- ◆ ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн нийт орлогын 99 хувийг борлуулалтын орлого эзэлж байна.

(мянган төгрөг)

Үзүүлэлтүүд	2024.I		2025.I	
	Дүн	Хувь	Дүн	Хувь
Борлуулалтын орлого (цэвэр)	25,655,869.97	99.0%	27,716,089.48	99.0%
Түрээсийн орлого	167,394.54	0.6%	242,779.54	0.9%
Хүүний орлого	34,374.90	0.1%	28,504.67	0.1%
Бусад орлого	59,001.80	0.2%	6,215.47	0.1%
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	2,156.71	0.0%	0.0	0.0%
Нийт орлого	25,918,797.9	100.0%	27,993,589.16	100.0%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	13,584,791.29	64.1%	14,725,297.43	62.3%
Борлуулалт, маркетингийн зардал	2,726,526.17	12.9%	2,528,480.75	10.7%
Ерөнхий ба удирдлагын зардал	3,157,587.97	14.9%	5,086,959.83	21.5%
Санхүүгийн зардал	540,369.84	2.5%	481,560.6	2.0%
Бусад зардал	235,819.90	1.1%	279,262.74	1.2%
Татварын зардал	536,826.58	2.5%	539,163.70	2.3%
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-0.05	0.0%	0.5	0.0%
Бусад алдагдал	-3,449.88	0.0%	13,512.22	0.1%
Нийт зардал	21,203,546.5	100.0%	23,654,237.79	100.0%
Тайлант үеийн цэвэр ашиг	4,715,251.4		4,339,351.37	

Хүснэгт 3. Орлогын тайлангийн үзүүлэлт

Бодлого, зохицуулалтын орчин

- Татварын багц хуульд нэмэлт өөрчлөлт орохтой холбогдуулан холбогдох саналыг хүргүүлсэн
- “MNS ISO 9202-1:2025, Үнэт эдлэл ба үнэт металл. Үнэт металлын хайлшны сорьц”, “MNS ISO 11596-2025, Үнэт эдлэл ба үнэт металл. Үнэт металл болон үнэт металлын хайлшнаас дээж авах арга”, “MNS ISO 15093-2025, Үнэт эдлэл, үнэт металл. Өндөр чанарын алт, цагаан алт, палатийг тодорхойлох нь. ICP-OES-ийг ашиглах өөр өөр арга” стандартуудын төсөлд холбогдох саналыг хүргүүлсэн.

Сургалт

“Тайлагнал болон МУТС-тэй тэмцэх чиглэл” сэдэвт мэдлэг олгох сургалтад ҮМҮЧЭТХЭАЭ-ийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдүүдийн эрх бүхий албан тушаалтнуудад 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан.



Хурал, уулзалт

ОХУ-ын Санкт Петербург хотод зохион байгуулсан олон улсын эрдэнийн чулуу, үнэт эдлэлийн “JUNWEX SAINT PETERBURG 2025” үзэсгэлэнд Санхүүгийн зохицуулах хорооны төлөөлөл 2025 оны 02 дугаар сарын 05-09-ний өдрүүдэд оролцож, туршлага солилцсон.

Хяналт шалгалт

Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөлтэй ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 55 хуулийн этгээд, 485 иргэнээс нийт 55 санхүүгийн тайлан, 248 арилжааны мэдээ ирүүлснийг хянан баталгаажуулж, салбарын нэгтгэлд хамруулсан.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдэд 46 зөвлөмж хүргүүлж, 9 хуулийн этгээдийг түдгэлзүүлсэн байна.



Тайлант хугацааны байдлаар нэр бүхий 55 хуулийн этгээд, 485 иргэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхэлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн тоо 5.8 хувиар, иргэдийн тоо 11.8 хувиар тус тус өссөн үзүүлэлт юм.

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭАЭ 55 хуулийн этгээд нь 85 хувьцаа эзэмшигчийн 10,164,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хувьцаа эзэмшигчдийн тоо 1.2 хувиар, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

ҮМҮЧЭТХЭАЭ 55 хуулийн этгээдийн 10,164,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 55.2 хувийг дотоодын хөрөнгө оруулалт, 44.8 хувийг гадаадын хөрөнгө оруулалт эзэлж байна.

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 282.1 кг үнэт металлыг 35,639,077.2 мянган төгрөгөөр худалдан авч, 193.1 кг үнэт металлыг 34,782,370.8 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь 2024 оны I улиралтай харьцуулахад худалдан авсан үнэт металлын хэмжээ 17.1 хувиар, худалдсан үнэт металлын хэмжээ 15.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид 2025 оны I улирлын байдлаар 119.1 кг алтыг 34,700,228.4 мянган төгрөгөөр худалдан авч, 114.8 кг алтыг 33,691,491.4 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь 2024 оны I улиралтай харьцуулахад худалдан авсан алтны хэмжээ 52.8 хувиар, худалдсан алтны хэмжээ 44.0 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант улиралд ҮМҮЧЭТХЭА эрхлэгчид нь нийт 163.0 кг мөнгийг 938,848.8 мянган төгрөгөөр худалдан авч, 78.3 кг мөнгийг 1,090,879.4 мянган төгрөгөөр худалдан борлуулсан бөгөөд 2024 оны I улиралтай харьцуулахад худалдан авсан мөнгөний хэмжээ 1.9 дахин, худалдан борлуулсан мөнгөний хэмжээ 3.3 дахин өссөн үзүүлэлт юм.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын 2025 оны I улирлын тайлангийн нэгтгэлд 55 хуулийн этгээд хамрагдсан бөгөөд 85 хувьцаа эзэмшигчдийн 10,164,429.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 85,884,172.0 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн байна.

- ◆ Тайлант хугацаанд нэр бүхий 55 хуулийн этгээд нь 27,993,589.2 мянган төгрөгийн нийт орлоготой, 23,654,237.8 мянган төгрөгийн нийт зардалтайгаар үйл ажиллагаа эрхэлсэн байна.
- ◆ Мөн ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүд нь 4,339,351.4 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс цэвэр ашгийн хэмжээ 375,900.0 мянган төгрөгөөр буюу 8.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- ◆ ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдүүдийн нийт орлогын 99 хувийг борлуулалтын орлого эзэлж байна.



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.

2025 ОН